



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/66

Мөрөн сум

“Шилдэг агентлаг, байгууллага, Шилдэг сумдын Засаг даргын Тамгын газар”-ыг шалгаруулах, шагнаж урамшуулах тухай.


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/515 дугаар захирамжийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр шалгарсан “Шилдэг агентлаг, байгууллага, Шилдэг сумдын Засаг даргын Тамгын газар”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Шилдэг агентлаг, байгууллага, Шилдэг сумдын Засаг даргын Тамгын газар”-ыг шагнаж урамшуулах зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан төсвийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Нямжав)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар
сарын 19-ны өдрийн А/8 дугаарын
захирамжийн 1 дүгээр хавсралт

2023 ОНЫ “ШИЛДЭГ АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГА, ШИЛДЭГ СУМДЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР”

Д/д	Шагнал	Агентлаг, байгууллага	Сумдын ЗДТГ
1	Тэргүүн байр	Орон нутгийн өмчийн газар	Бүрэнтогтох сумын ЗДТГ
2	Дэд байр	Татварын хэлтэс	Алаг- Эрдэнэ сум ЗДТГ
3	Гутгаар байр	Стандарт, хэмжил зүйн газар	Цагаан- Уул сум ЗДТГ
4	Дөтгөөр байр	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Түнэл сум ЗДТГ
5	Тавдугаар байр	Байгаль, орчин аялал жуулчлалын газар	Жаргалант сум ЗДТГ

__оОо__

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар
сарын 19-ны өдрийн А/66 дугаарын
захирамжийн 02 дугаар хавсралт

2023 ОНЫ “ШИЛДЭГ АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГА, ШИЛДЭГ СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫГ ШАГНАЖ УРАМШУУЛАХАД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

Д/д	Шагнал	Тоо ширхэг	Сумын ЗДТГ	Нийт Үнэ
1	Тэргүүн байр	1	2.000.000	2.000.000
2	Дэд байр	1	1.500.000	1.500.000
3	Гутгаар байр	1	1.000.000	1.000.000
4	Дөтгөөр байр	1	800.000	800.000
5	Тав дугаар байр	1	500.000	500.000
6	Тэргүүн байр	1	2.000.000	2.000.000
7	Дэд байр	1	1.500.000	1.500.000
8	Гутгаар байр	1	1.000.000	1.000.000
9	Дөтгөөр байр	1	800.000	800.000
10	Тавдугаар байр	1	500.000	500.000
11	Өргөмжлөл	10	30.000	300.000
12	Батламж	10	18.000	180.000
Нийт дүн				12.080.000

__оОо__